

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН 2010 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД  
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2011.03.28

Мөрөн сум

**Бодлогын зорилтыг хэрэгжүүлэх  
үйл ажиллагааны үр дүн**

Тайлант онд Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт – шинжилгээ хийж удааширч байгаа заалтууд дээр анхаарлаа хандуулж тодорхой төлөвлөгөө гарган холбогдох сум, хэлтэс, агентлагуудад үүрэг чиглэл өгч тодорхой ажил зохион ажиллаж ирсэний үр дүнд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр өссөн дүнгээр 72.2, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 70.6 хувийн хэрэгжилттэй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Хөвсгөл аймагтай холбогдох 97 зорилтын 176 заалт тусгагдсаныг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй нягт уялдуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үйл ажиллагааны үнэлгээ, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүдийг Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан Хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журмын дагуу хавсралтуудаар гарган хүргүүлж байгаа тул давхардуулахгүйгээр 2010 онд бодлогын чанартай авч хэрэгжүүлсэн гол гол ажлаасаа тоймловол:

Төрийн албан хаагчид иргэддээ хүрч ажиллаа - Төрийн албан хаагчдын аймгийн анхдугаар зөвлөгөөн хийж "Төрийн албаны сахилга хариуцлагыг дээшлүүлж иргэдтэйгээ ажиллах жил" болгон зарлаж ажилласан ба аймгийн нийт төрийн албан хаагчдын үйл ажиллагаандаа мөрдлөг болгох уриалга гарган биелэлтийг үр дүнгийн гэрээ, ажил дүгнэх нэг үзүүлэлт болгон тооцож, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, тэдний санал хүсэлтийг бодлого шийдвэрт тусгах зорилгоор хөдөөгийн багуудаар "БАГ-88" арга хэмжээ зохион байгуулсан зэрэг ажлуудын дүнд төрийн байгууллагуудын үйл ажиллагааг үнэлэх хэрэглэгчдийн /иргэд/ үнэлгээ өсөв.

- Онцлог бүтээн байгуулалтууд - Үндэсний баатар Хотгойдын шадар ван Чингүнжавын мэндэлсэний 300 жилийн ой, Хангайн бүсийн шилмэл хурдан морьдын "Хотгойд хурд-2 наадмыг өргөн тэмдэглэж , бүтээн байгуулалтын болон түүх соёл, урлаг спортын олон арга хэмжээ зохион байгуулсаны дотор Үндэсний баатар Чингүнжавын морьт хүрэл хөшөө, байгалийн боржин чулуун төв талбай, бүх сумдын онцлогийг харуулсан цэцэрлэгт хүрээлэн, Баатруудын цогцолбор, усан оргилуурт цэцэрлэгт хүрээлэн зэрэг түүх, соёл, байгалийн дурсгалт газруудыг бүтээж тохижуулав.
- Эрчимтэй хөгжлийн суурь болсон-Дэд бүтцийн салбар дахь хөрөнгө оруулалтууд - Мөрөн суманд дулааны станц, био-бүрэн цэвэрлэх байгууламж, Могойн голын нүүрсний уурхайд түшиглэж цахилгаан станц барих эхлэл тавигдаж ТЭЗҮ, зураг, төсөв нь хийгдэв, Аймгийн нисэх буудлыг олон улсын зэрэглэлтэй болгох зорилгоор өргөтгөлийн ажлуудыг эхлүүлэв. Хэвтээ босоо тэнхлэгийн замуудын ажилд дэвшил гарж, Мөрөн

суманд 3,9 км хатуу хучилттай авто зам хийгдэн, Эгийн голын төмөр бетон гүүрийг ашиглалтанд оруулж, Идэрийн голын гүүрийн ажлыг эхлүүлэв. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 28364.4 сая, орон нутгийн болон гадаад дотоодын зээл, тусламж, төсөл хөтөлбөр, иргэд, байгууллагын хандив, хувийн хөрөнгө оруулалтаар 24460.3 сая нийт 52.8 тэрбум гаруй төгрөгийн бүтээн байгуулалтын ажил хийгдлээ.

- “Оюунлаг-Хөвсгөл” - Ерөнхий боловсролын 13-н сургуулийн тэгш ой тохиож түүнийг угтсан олон бүтээлч ажил, хөрөнгө оруулалтууд хийгдэв. Мөрөн суманд 928, Галт, Жаргалант сумдад 640-н хүүхдийн сургууль шинээр ашиглалтанд оруулж, “Оюунлаг-Хөвсгөл” боловсролын хөтөлбөр батлав. Өмчийн хэлбэр үл харгалзан цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох норматив зардал олгож байгаа, бага боловсролын хамран сургалтын хувь дээшилж байгаа, аймгийн хэмжээнд сургуулийн ээлжийн коэффициентийг 1.5-аас, бүлэг дүүргэлтийг 30-аас хэтрүүлэхгүй байх бодлого барьж зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэний үр дүнд сургуулийн ээлжийн коэффициент 1.5-2.0 бүлэг дүүргэлт 30.5 хувьтай болоод байна. Мэргэжлийн хичээлүүдийн улсын олимпиадаас 16 медаль авч, математик, технологийн хичээлээр багаараа Улсын аварга боллоо.
- Хүний хөгжилд - хөрөнгө оруулалт:
  - Хүүхдэд – хүүхдийн ордон
  - Залуучуудад – Соёл, спортын цогцолбор
  - Эхчүүдэд – 50 ортой төрөх эмнэлэг, эхчүүдийн амрах байр
  - Ахмад настан – Ахмадын ордон, ахмадын сувилал
  - Малчдад – Ноос, ноолуурын үйлдвэр
- Нийтийн Соёл урлагийн олон арга хэмжээ:
  - Олон ястны урлагийн наадам, соёл урлагийн бага наадам зохион байгуулав
  - Тусгаар тогтнол-газар шороо улсын хэмжээний яруу найргийн наадам
  - Музей, номын сангийн байрыг стандартын дагуу өргөтгөн тохижуулж иж бүрэн ашиглалтанд оруулав
- Хөдөө аж ахуйн салбарын дэвшил - Өвөлжилтийн бэлтгэл хангах чиглэлээр малчин өрхөд санамж бичиг, сумдад албан даалгавар хүргүүлж, сум тус бүрийг аймгийн хэлтэс, агентлагуудад хариуцуулан ажилласнаар үр дүнд цас зудын хүнд нөхцөлд хэдийгээр малын тоо толгой хорогдсон ч улсдаа нийт малын тоо болон Зхушуу малаар улсдаа тэргүүлж, адуугаар тавдугаар байранд орсоноос гадна малын үүлдэр угсаа чанарт бодитой үр дүн гарч, өндөр ашиг шимт малын нийт малын тоонд эзлэх хувь өслөө. Мөн 6

дахь хушуу мал болох цаан сүргийнхээ тоог мянгад хүргэж 1000 цааны баяраа тэмдэглэж, аймгийнхаа гурилын хэрэгцээг бүрэн хангах буудай хураан авлаа.

- Нутгийн зөвлөл-хөгжлийн жигүүр –Улаанбаатар хот болон Эрдэнэт, Дархан бусад аймгуудад ажиллаж амьдардаг иргэдтэйгээ холбоо тогтоон нутгийн зөвлөлүүдтэй нягт хамтран ажилласны үр дүнд нутгаа гэсэн иргэдийн халуун сэтгэл, хандив дэмжлэг идэвхитэй өрнөж хөгжилд хөтлөх хос далавчтай болов. Нутаг орныхоо нэрийг өндөрт өргөж, хөгжил дэвшил, бүтээн байгуулалтанд үнэтэй хувь нэмэр оруулж буй хүмүүст Аймгийн дээд шагнал /Хөвсгөлийн хүндэт иргэн, Чингүнжавын одон, Хөвсгөлийн бахархал/ -ууд олгов.
- Хамтдаа хөгжил – Бизнесийн орчны шинэтгэлийн жилийн хүрээнд аймгийн “Үйлдвэрлэлийг дэмжих” хөтөлбөрийг батлаж, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлттэй зээлийг үргэлжлүүлэн олгосны үр дүнд тайлант онд шинээр 129 жижиг дунд үйлдвэр нэмэгдэж 810 байнгын ажлын байр бий болгож, татварын орлогыг нэмэгдүүлсэн томоохон хөрөнгө оруулалтуудыг өөрсдийн хүчээр хийлээ
- Төсвийн орлогын баазыг өргөтгөх, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулахад анхаарч, татвар төлөгч ААН, байгууллагын тоог 12 хувь, татварт хамрагч иргэний тоог 18 хувиар өсгөн орлогын хөөц боломжийг дайчлан төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг 121.6 хувьд хүргэж, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах ажил өрнүүлсэнээр үргүй зардал багасч, төсвийн хэтрэлтгүй ажиллаж, төсвийн урсгал авлагыг 57.7 хувиар багасгаж, төсвийн урсгал өрийг бүрэн барагдууллаа.
- Төрийн албаны Зөвлөлөөс 2010 оныг “ Төрийн албаны стандартыг хангах жил “ болгон зарласны хүрээнд аймгийн хэмжээн дэх бүх төрийн байгууллагууд, төрийн албан хаагчдын чадавхийг дээшлүүлэх, хариуцлагыг өндөржүүлэх , төрийн албаны стандартыг ханган хэвшүүлэх зэрэг ажлуудыг жилийн хэмжээнд төлөвлөн хэрэгжүүлсэн ба цаашид ч энэ шаардлага, зорилтоо үргэлжлүүлэн хэрэгжүүлэх болно. Энэ ажлын хүрээнд “Тогтмол хэвшүүлэх ажил”-ыг өрнүүлэн хэлтэс, агентлагууд болон төрийн бүх байгууллагуудад зохиох, хамтран ажиллах 10 ажил төлөвлөн баталж хэрэгжүүллээ. Үүнд: Мэдээллийн цаг, Хуулийн цаг, Төр ба иргэн хамтын зүтгэл, Шуурхай цуглаан, Байгууллагуудад ЗДТГ-аас ажиллах графикт ажлууд, Төрөлжсөн сургалтууд /Сумд болон төрийн албаны байгууллага, ажилтнуудад/, Түвшин тогтоох шалгалтууд , Төрөлжсөн өдөрлөгүүд зэрэг ажлуудыг дурьдаж болно. Мөн төрийн албан хаагч бүрт өөрийн ажил албатай холбогдолтой болон төрийн албаны ерөнхий стандарт, эрх зүйн акт гарын авлагуудыг багтаасан “Ширээний ном”- той болгон ажил албанд нь ашиглуулж байна. Дээрх ажлуудын үр дүнд төрийн албан хаагчдын чадавх дээшилж, төрийн байгууллагуудын ажил жигдэрч, төрийн албаны стандарт, албан хэрэг хөтлөлт , мэдээ тайлангийн үнэн бодит байдал сайжирсанаас гадна одоогоор ажил нь дүгнэгдсэн ЗДТГ-ын болон Засаг даргын эрхлэх

асуудлын хүрээний хэлтэс, газар, албад, төрийн байгууллагуудаас 2010 оны ажлаараа системийнхээ хэмжээнд Хөгжлийн бодлогын хэлтэс- Үндэсний хөгжил , шинэтгэлийн хорооноос “Бизнесийн орчны шинэтгэлийн жилийн ажлыг дүгнэсэн үзүүлэлтээр 1-р байр, Биеийн тамир, спортын газар 1-р байр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба 1-р байр, Тээвэр, авто замын газар 2-р байр, Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс 3-р байр, Байгаль орчин, аялал жуулчлалын газар 3-р байр Статистикийн хэлтэс 4-р байр, Гаалийн алба 6-р байр, Цагдаагийн газар –Хангалттай сайн, Хүнс,хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар- Хангалттай сайн, эхний 10-т, Хөдөлмөр,халамжийн үйлчилгээний хэлтэс- эхний 10- т орж оны ажлаа дүгнүүлээд байна.

2010 онд аймгийн ЗДТГ-ын болон аймгийнхаа бүх сумд, төрийн бүх шатны байгууллага,төрийн албан хаагчдынхаа хүч хөдөлмөрийг дэвшүүлсэн зорилтоо хангахад бүрэн дайчилж,Засгийн газар, яам агентлагуудтай нягт хамтран дэмжлэг туслалцаа авч ажилласны дүнд дээрх амжилтад хүрч ажиллаа.

2011 оныг аймгийн хэмжээнд “Тунгалаг засаглалын жил” болгон зарлаж төрийн үйлчилгээг иргэдэд улам бүр ойртуулах төрийн албан хаагчдын чадавхийг дээшлүүлэх зэрэг зорилтууд дэвшүүлэн жилийн төлөвлөгөө гарган ажиллаж байна

Мөн энэ онд Ардын хувьсгалын 90 жилийн ойтой давхцан аймаг байгуулагдсаны 80 жилийн ой тохиох тул 80 жилийн ой угтсан 80 бүтээлч ажлын жагсаалт гарган аймгийн Засаг даргын зөвлөл,ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн баталж хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган бүх сум байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлсэн бөгөөд энэ он бүтээн байгуулалтын жил байх болно

ТАНИЛЦСАН :

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН

ДАРГА

Г.ТӨМӨРБААТАР

ТАЙЛАН БИЧСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН

ХЭЛТСИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ

ТАСГИЙН ДАРГА

Ч.БЯМБАДОРЖ

